



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/388

Есөнбулаг

Газар эзэмших эрхийг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 59 дүгээр тогтоол, Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 133/ШШ2023/00525 дугаар шийдвэрүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ахмадын хорооны үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 8208001719 нэгж талбарын дугаартай 406 м2 газрыг иргэн Гэлэгбуугийн Батбаярт эрх шилжүүлж, эзэмшил газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн иргэний мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/36 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын
 2014 оны 06 дугаар сарын 03 -ны
 өдрийн 39 дугаар захирамжийн
 хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
 ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Г.Батбаяр	ДЭ87110314	Эзэмших	8208001719	406	Оргил баг	Үйлчилгээ (2111)	10